

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Парламентын сонсгол зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой хэдий ч сонсголын үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцож, шалгах үр дүнгийн сонсголын зохион байгуулах нь парламентын аливаа шийдвэр, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний биелэлтийг тооцох, нээлттэй сонсох нь түүнтэй адил чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасны дагуу Улсын Их Хурал нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй бөгөөд парламентын нээлттэй сонсгол бол Улсын Их Хурал хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдолтой, олон нийтийн оролцоотой механизм болдог.

Энэхүү зорилго, ач холбогдлыг тусгаж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах Засгийн газрын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн биелэлтийг Улсын Их Хурлаас хянан шалгахтай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж 2024 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Мөн уг хууль батлагдсантай холбоотойгоор Нийтийн сонсголын тухай хуульд заасан ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу явуулахаар хуульчилсан.

Дээр дурдсанаар парламентын сонсгол зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой хэдий ч сонсголын үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний биелэлт, үр дүнг тооцож, шалгах үр дүнгийн сонсголын зохион байгуулах нь парламентын аливаа шийдвэр, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний биелэлтийг тооцох, нээлттэй сонсох ач холбогдолтой юм.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болох зорилгын хүрээнд 2021-2030 онд Улсын Их Хурлын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавх сайжирч парламентын засаглал бэхэжсэн байхаар хүрэх үр дүнг тодорхойлсон.

Иймд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн үндсийг хуульчлах шаардлагыг харгалзан Монгол Улсын Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу зохион байгуулсан хяналтын сонсголоос гарсан санал, дүгнэлт, чиглэлтэй холбоотойгоор үр дүнгийн сонсголыг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн үндсийг тодорхойлсон хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь үр дүнгийн сонсгол зохион байгуулах эрх зүйн үндсийг тодорхойлох бөгөөд уг хуулийн 6 дугаар бүлэг буюу Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол, түүний төрөл, зохион байгуулалттай холбоотой 26 дугаар зүйлд нэмэлт оруулахаар боловсруулав.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ